



МОНГОЛ УЛСЫН НИЙГМИЙН
ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2012 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

“Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж,
санхүүжилт /тарифаар тооцож/ олгох
журам”-ыг батлах тухай


Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.4 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт олгох журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Ажил хайгчдаас ажилд зуучлуулсан болон оруулсан хүний тоогоор санхүүжилт олгох тариф”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Энэ тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /Д.Баярсайхан/, Хөдөлмөрийн төв бирж /А.Зангад/-т даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2007 оны “Төлбөрийн хэмжээ тогтоох тухай” 97 дугаар тушаал, 2010 оны “Журам шинэчлэн батлах тухай” 104 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Т.ГАНДИ



Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт олгох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэх болон санхүүжилт олгох үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагааг хуулийн этгээд эрхэлж болно.

1.3. Хөдөлмөрийн хувийн биржийг хөдөлмөрийн төв бирж болон аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүртгэж, мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбоно.

1.4. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон хөдөлмөрийн хувийн биржид сүлжээнд бүртгэгдсэн ажил хайгчдаас ажилд зуучлуулсан болон оруулсан хүний тоогоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас тогтоосон тарифаар тооцож санхүүжилт олгоно.

1.5. Энэхүү журмын дагуу бүртгүүлсэн хөдөлмөрийн хувийн бирж нь ажилд зуучлуулсан болон оруулсан иргэнээс шууд ба шууд бус байдлаар үйлчилгээний төлбөр авахыг хориглоно.

Хоёр. Хөдөлмөрийн биржийг бүртгэх, бүртгэлээс хасах

2.1 Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлийг хийж, Хөдөлмөрийн төв бирж мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбоно.

2.2 Хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлэхэд дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

2.2.1. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

2.2.2. ажилд зуучлах үйлчилгээг зохион байгуулах удирдах ажилтан /захирал/-ны ажилд томилогдсон шийдвэр болон иргэний үнэмлэхний хуулбар;

2.2.3. хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний үлгэрчилсэн журамд нийцүүлэн боловсруулсан хөдөлмөрийн хувийн биржийн зуучлалын үйлчилгээний журам;

2.2.4. ажлын байрны талаар мэдээлэл авах болон ажилд зуучлах үйлчилгээнд ашиглах тоног төхөөрөмж болон материалын жагсаалт;

2.2.5. ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн зөвлөх, зохих мэдлэг, ур чадвар эзэмшсэн үйлчилгээний ажилтны анкет;

2.2.6. нэг цэгийн үйлчилгээний үйлчилгээний байр, техник хэрэгслээр хангагдаж, хэрэглэгчдэд мэдээллийг интернетийн орчинд үзүүлэх боломжтой байх;

2.2.7. тухайн биржийн үйл ажиллагаа явуулах аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага болон хөдөлмөрийн төв биржийн санал дүгнэлт.

2.3. Хөдөлмөрийн хувийн бирж нь энэ журмын 2.2-т заасан зохих материалыг бүрдүүлж бүртгүүлэх хүсэлтээ хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

2.4. Хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагаа эрхлэхээр гаргасан хүсэлтийг үндэслэн бүртгэлийн гэрчилгээг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр 2 жилийн хугацаатай олгож, сунгана. Гэрчилгээ улсын хэмжээний нэгдсэн загвар, бүртгэлийн дугаартай, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хүчинтэй хугацаатай байна.

2.5. Хөдөлмөрийн хувийн биржийг дараах тохиолдолд үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлсэн бүртгэлээс хасна. Үүнд:

2.5.1. хөдөлмөрийн хувийн бирж өөрөө хүсэлт гаргасан, хуулийн этгээд татан буугдсан;

2.5.2. гэрчилгээ авах хүсэлт гаргахдаа хуурамч материал бүрдүүлсэн нь холбогдох байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;

2.5.3. иргэнээс зуучлалын хөлс хураамж авсан, эсхүл хураамжийг цалин хөлснөөс нь суутгаж авсан нь зохих ёсоор тогтоогдсон;

2.5.4. иргэнийг хууль бус үйл ажиллагаатай холбоотой ажилд зуучилсан болон зуучлалын үйл ажиллагаа нь холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн нь хуулийн болон мэргэжлийн хяналтын дүгнэлтээр тогтоогдсон;

2.5.5. зургаан сарын хугацаанд ажилд зуучлах үйлчилгээ явуулаагүй, тайлан, мэдээ ирүүлээгүй.

2.6. Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэлээс хассан шийдвэрийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гаргаж, хөдөлмөрийн төв бирж болон тухайн хувийн биржид мэдэгдэн зуучлалын үйл ажиллагааг зогсооно.

2.7 Хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний үлгэрчилсэн журмыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага баталж мөрдүүлнэ.

Гурав. Хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагаа, санхүүжилт

3.1 Хөдөлмөрийн хувийн бирж нь дараах хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

3.1.1. хөдөлмөрийн зах зээлд оролцогчийг бүртгэх, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх;

3.1.2. ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох;

3.1.3. ажилд зуучлах;

3.1.4. нийт болон сул чөлөөтэй ажлын байр, шинээр бий болсон, байхгүй болсон ажлын байрны, түүнчлэн ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэний зэрэг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулан авч хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулах;

3.1.5. хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах;

3.1.6. хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

3.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөдөлмөрийн хувийн биржид ажил хайгчдаас ажилд зуучлуулсан болон оруулсан хүний тоогоор тооцож хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлсэн байдал, ажил олоход хүндрэлтэй бүлэг зэрэгт чиглэсэн үйл ажиллагааны үр дүнг харгалзан санхүүжилтийг гэрээний дагуу хийнэ.

3.3. Хөдөлмөрийн хувийн бирж санхүүжилт авах хүсэлтээ хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн ажилд зуучлуулсан болон оруулсан хүний талаарх мэдээлэл, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн дүнг үндэслэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага санхүүжилтийг олгоно.


Дөрөв. Хөдөлмөрийн хувийн бирж йл ажиллагааны тайлан, мэдээ гаргах

4.1 Хөдөлмөрийн хувийн бирж нь ажилд зуучлах үйл ажиллагаатай холбогдсон тайлан, мэдээгээ сар бүрийн 3-ны дотор аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад тогтоосон маягтаар хүргүүлнэ.

4.2 Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага хөдөлмөр хувийн биржийн тайлан, мэдээг нэгтгэж хөдөлмөрийн төв биржид сар бүрийн 5-ны дотор хүргүүлнэ.

4.3 Ажилд зуучлах үйлчилгээний тайлан, мэдээний маягтыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

_____ооо_____



Хөдөлмөрийн хувийн биржид ажил хайгчдаас ажилд зуучлуулсан болон оруулсан хүний тоогоор санхүүжилт олгох тариф

/мянган төгрөгөөр/

Зорилтот бүлгүүд	Ажил хайгчдаас ажилд зуучлахад олгох зардлын хэмжээ	Ажил хайгчдаас ажилд оруулахад олгох зардлын хэмжээ	
		Аж ахуйн нэгж, байгууллагад 3 сараас дээш хугацаагаар ажиллаж байгаа бол	Аж ахуйн нэгж, байгууллагад 6 сараас дээш хугацаагаар ажиллаж байгаа бол
Ажил олоход хүндрэлтэй иргэн	20000	40400	100000
45 дээш насны ажилгүй иргэн		35300	70000
25 хүртэл насны ажилгүй залуучууд		35300	70000
Ажил хайгч болон ажилгүй иргэн		30200	40000

Жич: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.1-3.1.5 заалтын дагуу “ажил хайгч” болон “ажилгүй иргэн”, 3.1.7 заалтын дагуу “ажил олоход хүндрэлтэй иргэн”, 3.1.10 заалтын дагуу “ажилд зуучлах” гэдгийг ойлгох бөгөөд ажил хайгчдаас ажилд зуучлахад олгох зардалд энэ журмын 3.1.1-3.1.4 заасан нийтлэг үйлчилгээний зардлууд багтана.

Хөдөлмөрийн хувийн бирж зорилтот бүлгийн иргэнийг зуучилж, 6 сараас дээш хугацаагаар нийгмийн даатгалын шимтгэл төлүүлж ажиллуулсан бол Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 100 хувиар ажил олоход хүндрэлтэй иргэний, 75 хувиар 45-аас дээш, 25 хүртэл насны ажилгүй иргэний, 50 хувиар ажил хайгч иргэний зардлыг тус тус тооцож олгоно.